

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮЯ	Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн Яам
ХАА	Хөдөө аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ М.БЯМБАСҮРЭН ТАНАА

2021.02.25 № 07/542
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эрдэм шинжилгээний ажлын хүрээнд 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	376,594,053.72	149,904,686.72
33	АВЛАГА	5,010,000.00	-
33300	Татаас санхүүжилтийн авлага	5,010,000.00	-
34	УРЬДЧИЛГАА	106,897,600.00	138,724,763.72
34600	Урьдчилж гарсан зардал	106,897,600.00	138,724,763.72
35	БАРАА МАТЕРИАЛ	264,686,453.72	11,179,923.00
351	Түүхий эд материал	-	433,470.00
35110	Тусгай зориулалтын материал	-	433,470.00
354	Хангамжийн материал	264,686,453.72	10,746,453.00
35410	Бичиг хэргийн материал	8,865,220.00	1,431,560.00
35420	Аж ахуйн материал	241,671,563.72	9,314,893.00
35430	Сэлбэг хэрэгсэл	14,149,670.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	778,165,710.19	748,498,527.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	778,165,710.19	748,498,527.97
392	Биет хөрөнгө	454,498,750.03	424,908,567.79
39201	Барилга байгууламж	86,949,692.00	86,767,692.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(12,349,119.65)	(14,745,512.85)
39203	Авто тээврийн хэрэгсэл	47,003,287.69	36,303,925.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,003,287.69)	(36,303,925.00)
39205	Машин тоног төхөөрөмж	839,054,524.53	785,381,258.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(476,987,123.21)	(463,530,711.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	124,950,472.33	48,371,309.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(109,470,913.21)	(19,686,685.33)
39209	Номын фонд	2,351,217.24	2,351,217.24
393	Биет бус хөрөнгө	323,666,960.16	323,589,960.18
39301	Программ хангамж	1,770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,615,999.84)	(692,999.82)
39303	Бусад биет бус хөрөнгө	323,512,960.00	323,512,960.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,154,759,763.91	898,403,214.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,154,759,763.91	898,403,214.69
51	Засгийн газрын хувь оролцоо	1,154,759,763.91	898,403,214.69
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	563,664,858.93	563,664,858.93
51101	Өмч: -Төрийн өмч	563,664,858.93	563,664,858.93
512	Хуримтлагдсан үр дүн	511,690,889.92	255,334,340.70
51210	Өмнөх үеийн үр дүн	639,200,086.03	511,690,889.92
51220	Тайлант үеийн үр дүн	(127,509,196.11)	(256,356,549.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	79,404,015.06	79,404,015.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,154,759,763.91	898,403,214.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	868,857,900.00	999,842,470.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,170,000.00	13,891,570.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,170,000.00	13,891,570.00
12004	Төсөв байгууллагын орлого	3,170,000.00	13,891,570.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,170,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	13,891,570.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	865,687,900.00	985,950,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	756,187,900.00	792,590,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	756,187,900.00	792,590,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,500,000.00	193,360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	109,500,000.00	72,800,00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	120,560,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	996,367,096.11	1,256,199,019.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	986,139,990.11	1,256,199,019.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	986,139,990.11	1,227,103,842.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,745,230.00	667,526,830.00
210101	Цалин	421,096,230.00	489,660,389.20
210102	Нэмэгдэл цалин	83,183,800.00	148,480,860.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,456,200.00	29,385,580.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,316,429.00	84,577,595.86
210201	Тэтгэврийн даатгал	45,775,171.72	61,992,012.47
210202	Тэтгэмжийн даатгал	5,385,314.32	5,732,629.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,308,251.46	8,017,741.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,077,062.86	1,118,224.48
210205	Эрүүл мэндийн даатгал	10,770,628.64	7,716,987.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	847,562.00	734,688.00
210301	Гэрэл цахилгааны зардал	847,562.00	734,688.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,763,847.00	12,745,332.91
210401	Бичиг хэрэг	1,135,328.00	9,220,250.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,069,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,334,519.00	1,513,582.91
210404	Ном, хэвлэлийн зардал	294,000.00	816,100.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	125,900.00
2105	Нормативт зардал	735,056.00	409,195.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	735,056.00	409,195.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,900,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	4,900,000.00
2107	Томилолт, зочны зардал	72,883,594.00	27,697,200.00

210702	Дотоод томилолтын зардал	72,883,594.00	27,697,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	223,087,901.00	379,999,849.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	220,067,931.00	376,580,549.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	71,300.00	71,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,670.00	159,000.00
210805	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	246,400.00	246,400.00
210807	Газрын төлбөр	521,600.00	920,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,760,371.11	48,513,152.22
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	97,760,371.11	48,513,152.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,227,106.00	29,095,176.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	922,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	600,000.00	922,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,627,106.00	28,172,676.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,512,215.00	23,874,295.23
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	114,891.00	4,298,381.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(127,509,196.11)	(256,356,549.22)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(127,509,196.11)	(256,356,549.22)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	868,857,900.00	990,960,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,170,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	3,170,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,170,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,170,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	865,687,900.00	990,960,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	756,187,900.00	792,590,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	756,187,900.00	792,590,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,500,000.00	198,370,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	109,500,000.00	77,810,00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	120,560,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	860,348,500.00	986,006,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	860,348,500.00	986,006,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,111,394.00	956,911,323.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,734,200.00	664,146,757.00
210101	Үндсэн цалин	421,085,200.00	485,499,380.00
210102	Нэмэгдэл	83,183,800.00	164,922,977.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,456,200.00	13,724,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,316,429.00	84,577,595.86
210201	Тэтгэврийн даатгал	45,775,171.72	61,992,012.47
210202	Тэтгэмжийн даатгал	5,385,314.32	5,732,629.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,308,251.46	8,017,741.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,077,062.86	1,118,224.48
210205	Эрүүл мэндийн даатгал	10,770,628.64	7,716,987.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	847,562.00	734,688.00
210301	Гэрэл цахилгааны зардал	847,562.00	734,688.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,546,519.00	12,979,182.91
210401	Бичиг хэрэг	3,268,000.00	9,634,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	889,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,334,519.00	1,513,582.91
210404	Ном, хэвлэлийн зардал	7,744,000.00	816,100.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	125,900.00
2105	Нормативт зардал	550,000.00	424,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	424,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,900,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	4,900,000.00
2107	Томилолт, зочны зардал	72,883,594.00	27,697,200.00
210702	Дотоод томилолтын зардал	72,883,594.00	27,697,200.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	169,233,090.00	161,451,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	165,907,714.00	158,032,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	71,300.00	71,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,670.00	159,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	246,400.00	246,400.00
210807	Газрын төлбөр	827,006.00	920,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,237,106.00	29,095,176.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	922,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	922,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,637,106.00	28,172,676.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,512,215.00	23,874,295.23
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт	5,124,891.00	4,298,381.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,509,400.00	4,954,400.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00-	0.00-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	8,509,400.00	4,954,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,509,400.00	4,954,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,509,400.00	4,954,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,509,400.00	4,954,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,509,400.00)	(4,954,400.00)
8	САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00-	0.00-
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00-	0.00-
ЭХ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00-	0.00-
ЭЦ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00-	0.00-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	563,664,858.93	79,404,015.06	639,200,086.03	1,282,268,960.02
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			(127,509,196.11)	(127,509,196.11)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	563,664,858.93	79,404,015.06	511,690,889.92	1,154,759,763.91
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(256,356,549.22)	(256,356,549.22)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	563,664,858.93	79,404,015.06	255,334,340.70	898,403,214.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	792,590,900.00	768,716,604.77	23,874,295.23	97.0
21	УРСГАЛ ЗАРДАЛЫН ДҮН	792,590,900.00	768,716,604.77	23,874,295.23	97.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	791,668,400.00	767,794,104.77	23,874,295.23	97.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	674,923,900.00	659,763,007.00	15,160,893.00	97.7
210101	Үндсэн цалин	486,912,800.00	481,115,630.00	5,797,170.00	98.8
210102	Нэмэгдэл	171,545,900.00	164,922,977.00	6,622,923.00	96.1
210103	Унаа болон бусад нөхөн олговор	16,465,200.00	13,724,400.00	2,740,800.00	83.3
21002	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,789,800.00	84,029,626.86	7,760,173.14	91.5
210201	Тэтгэврийн даатгал	64,592,900.00	61,444,043.47	3,148,356.53	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	6,799,200.00	5,732,629.84	1,066,570.16	84.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,439,400.00	8,017,741.20	(2,578,341.20)	147.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,359,800.00	1,118,224.48	241,575.52	82.2
210205	Эрүүл мэндийн даатгал	13,598,500.00	7,716,987.87	5,881,512.13	56.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	737,100.00	734,688.00	2,412.00	99.7
210301	Гэрэл цахилгаан	737,100.00	734,688.00	2,412.00	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	4,001,400.00	3,054,782.91	946,617.09	77.5
210401	Бичиг хэрэг	722,400.00	222,400.00	500,000.00	30.8
210402	Тээвэр, шатахуун	889,500.00	889,500.00	-	104.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,513,600.00	1,513,582.91	17.09	100.0
210404	Ном, хэвлэл	400,000.00	303,400.00	96,600.00	75.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгал	125,900.00	125,900.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	350,000.00	-	350,000.00	100.0
2105	Нормативт зардал	424,200.00	424,200.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	424,200.00	424,200.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,792,000.00	19,787,800.00	4,200.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,368,500.00	16,368,500.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	71,300.00	71,300.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,200.00	159,000.00	4,200.00	97.43
210805	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	22,000.00	22,000.00	-	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	246,400.00	246,400.00	-	100.0
210807	Газрын төлбөр	920,600.00	920,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	922,500.00	922,500.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	922,500.00	922,500.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	922,500.00	922,500.00	-	100.0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	792,590,900.00	768,716,604.77	23,836,895.23	97.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	792,590,900.00	768,716,604.77	23,836,895.23	97.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	792,590,900.00	768,716,604.77	23,836,895.23	97.0
65	АЖИЛЛАГСДЫН ТОО	45	45		100.0

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

650001	Удирдах ажилтан	1	1		100.0
650002	Гүйцэтгэх ажилтан	39	39		100.0
650009	Үйлчлэх ажилтан	5	5		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		198,370,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ		198,370,000.00
Үндсэн үйл ажиллагааны зардал		71,931,619.00
Бараа ажил үйлчилгээний зардал		67,031,619.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		4,383,750.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		547,969.00
Хангамж, бараа материалын зардал		9,924,400.00
Бичиг хэрэг		9,411,700.00
Ном, хэвлэл		512,700.00
Эд хогшил, урсгал засварын зардал		4,900,000.00
Томилолт, зочны зардал		27,697,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		24,478,300.00
Эрдэм шинжилгээ судалгааны ажил		126,438,381.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		122,140,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		4,298,381.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		4,298,381.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		198,370,000.00
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		108,600,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан, төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		72,800,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		16,970,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг М.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсөвт байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг дагаж мөрдөх, анхан шатны баримтын хүчин төгөлдөр байдал, бараа материалын зарцуулалт болон холбогдох заавар, журам, шийдвэрийг дагаж мөрдөх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 10-наас 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Аккурэйт финанс Аудит ХХК-ийн захирал Ж.Оюунбилэг аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Д.Сайнбаяр, гэрээт аудитор Я.Золзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Аккурэйт финанс Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол орны бэлчээр, хадлан, ой, ногоон байгууламж, таримал ургамлын өвчин, хортон шавьж, мэрэгч амьтан, хог ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, хор хөнөөлийг тогтоож, хөнөөлт зүйлүүдийн био-экологийн онцлогийг судалж, өсөлт хөгжлийн зүй тогтол, тархалт, олшролтын прогноз гарган, тэмцэх цогцолбор арга, дэвшилтэт технологи боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх ургамлын гаралтай бүтээгдэхүүнд чанарын үнэлгээ, пестицидийн үлдэгдлийг судлах, байгаль орчинд халгүй аргыг боловсруулж, ургац нэмэгдүүлэх, эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангахад оршино.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ургамлын өвчин, хортон шавьж, мэрэгч амьтан, хог ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тархалт, хор хөнөөлийг тогтоох,
- Хөнөөлт организмуудын зүйлүүдийн био-экологийн онцлогоос нарийвчлан судалж, өсөлт хөгжлийн зүй тогтол, тархалт, олшролтын прогноз гаргах,
- Тэмцэх цогц арга, дэвшилтэт технологи боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх, байгаль орчинд халгүй тэмцэх арга боловсруулах,
- Ургамлын гаралтай бүтээгдэхүүнд чанарын үнэлгээ хийх, бордоо, пестицидийн үлдэгдлийг тогтоох,
- Бэлчээр, байгалийн ургамлыг хамгаалах, ойн доройтол, нөхөн сэргээх дэвшилтэт арга технологи боловсруулж, нэвтрүүлэх,
- Монгол оронд ургамал хамгааллын зориулалтаар ашиглагдах хими, биологийн бэлдмэлүүд, бордоо, ургамлын өсөлт идэвхжүүлэгч, ургамал хамгааллын зориулалттай бодис, бүтээгдэхүүний идэвх, чанар, аюулгүй байдал, үлдэгдлийн судалгааг хийх, хяналт тавих,

- Ургамал хамгааллын чиглэлийн мэргэжлийн байгууллага, лабораториудын гаргасан шинжилгээний дүнг хянах, баталгаажуулах, сургах, мэргэшүүлэх,
- Судалгаа, сургалт, инновац-үйлдвэрлэл, хяналт-үйлчилгээний байгууллагын нийтлэг үнэт зүйл, зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгох, ургамал хамгааллын чиглэлээр судалгааны үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд доорх өөрчлөлт орсон байна. Үүнд:

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь БСШУСЯ-ны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг мөрдөж байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 онд санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд БШУЯамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар дотоод хяналт шалгалт хийж зөвлөмж өгсөн байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 434,956.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,349.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,256,199.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,562.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцов.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 256,356.5 мянган төгрөгөөр буюу 22.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	5,010.0	-	(5,010.0)
Урьдчилгаа	106,897.6	138,724.8	31,827.2
Бараа материал	264,686.4	11,179.9	(253,506.5)
Үндсэн хөрөнгө	778,165.7	748,498.5	(29,667.2)
Нийт хөрөнгө	1,154,759.7	898,403.2	(256,356.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,154,759.7	898,403.2	(256,356.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,154,759.7	898,403.2	(256,356.5)

Авлага дансны үлдэгдэл 5,010.0 мянган төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлагыг авснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,179.9 мянган төгрөг болж 253,506.5 мянган төгрөгөөр буурсан нь 77,976.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 331,482.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 748,498.5 мянган төгрөг болж 29,667.2 мянган төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 4,954.4 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, БШУЯ-аас үнэ төлбөргүйгээр 13,891.5 мянган төгрөгийн үнэтэй 7 ширхэг компьютер хүлээн авч, нийт 18,845.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн 48,513.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, 160,979.7 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2020 оны 705 тоот тогтоолоор акталсан нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 898,403.2 мянган төгрөг болж 256,356.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 130,984.5 мянган төгрөгөөр буюу 13.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс туслах үйл ажиллагааны орлого 3,170.0 мянган төгрөгөөр буурч, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 13,891.5 мянган төгрөгөөр, санхүүжилтийн орлого 120,263.0 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна

Нийт зардал өмнөх оноос 259,831.9 мянган төгрөгөөр буюу 20.6 хувиар өсөж өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд цалин, нэмэгдэл урамшууллын зардал 146,781.6 мянган төгрөг, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 17,261.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 9,981.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 4,900.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, 156,911.9 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Харин байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 112.8 мянган төгрөг, нормативт зардал 325.8 мянган төгрөг, томилолт, зочны зардал 45,186.3 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 18,545.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 49,247.2 мянган төгрөгөөр тус тус буурсантай байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 811,154.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 811,154.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 18,600.8 мянган төгрөгөөр бууруулж 792,553.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 792,553.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 792,553.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 768,716.6 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 22,920.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 909.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 4.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 768,716.6 мянган төгрөг буюу Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 23,836.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71808	Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	792,553.0	768,716.6	(23,836.9)	97.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	792,553.0	768,716.6	(23,836.9)	97.0
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	922.5	922.5	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 181,400.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого.16,970.0 мянган төгрөг нийт 198,370.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 4,383.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 547.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 9,924.4 мянган төгрөг, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд 126,438.3 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 136 мэдээллээс хугацаандаа оруулсан 118 мэдээлэл, бүтэн жилээр оруулах 2 мэдээлэл, тухай бүрд оруулах 8 мэдээлэл, гэх мэт 18 мэдээ хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	45,457.0	4	45,457.0	-	-	100.0
Нийт дүн	4	45,457.0	4	45,457.0	-	-	100.0

Өмнөх аудитаар акт, албан шаардлага өгөөгүй бөгөөд 4 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг хянахад мөнгөн гүйлгээний тайланг нөхөн гаргаж 2,000.0 мянган төгрөгийн төсөт төвлөрүүлж, 770.0 мянган төгрөгийг 100900015464 тоот дансанд шилжүүлсэн байна. Бараа материалын зөрүүтэй үлдэгдлийг зарлагдаж эд хариуцагч нарын тайлан гаргаж, үлдэгдлийн бүртгэл хөтлөж зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Цалингийн зардлын төсвийг хэтрүүлээгүй ч 1992 онд 4 сектор 45 ажилтантайгаар батлагдсан орон тоогоор одоог хүртэл ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагааны чиглэл өргөжиж 8 лабораторитой болсон байна. Орон тоо нэмэгдүүлэх хүсэлтийг БШУЯам-д албан тоотоор хүргүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,471.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулж байх тухай албан шаардлага, 10,471.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай тайлагнаагүй залруулах асуудал байгаагүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 136 мэдээллээс 18 мэдээ хугацаа хоцроосон зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Шилэн дансны цахим хуудсанд 18 мэдээ хугацаа хоцроосон зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”,

6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулж байх тухай албан шаардлага хүргүүлэв

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 10,471.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

ХХААХҮЯ-ны дэмжлэг, Азийн хөгжлийн банк, ХАА, Хөдөөгийн хөгжлийн төслийн санхүүжилтээр хүлээн авсан 107,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий “Шавьж наалдуулагч шар цаасан урхи” үйлдвэрлэх иж бүрэн машиныг захиалагч байгууллага эргэлтийн хөрөнгөндөө тайлагнасан, ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын тайлан, орлого зарлагын гүйлгээг түүвэрлэн шалган үзэхэд орлогын падаангүй, харилцагч байгууллагын дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримгүй 4,693.4 мянган төгрөгийн бараа материалын орлого байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын хавсралт 3,2-д "Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирсэн материал, үнэ бүхий зүйлийг орлого болгоход эд хариуцагч нар дагалдан ирсэн бичиг баримтыг үндэслэн орлогын баримтыг 2 хувь бичих", 3,5-д "Бараа, материалын үнэ бүхий зүйлийн орлого, зарлагын баримт"-ийг үндэслэн агуулахын бүртгэлийг биет нэгжээр хөтөлж өдөр тутмын үлдэгдлийг тодорхойлох" гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Бараа материал хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, ашиглалтад тавих хяналт сулрах

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл.Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"... гэснийг дагаж мөрдөх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг дахин давтахгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тээвэр шатахуун зардлын дансыг шалган харилцахын анхан шатны баримтуудтай тулган үзэхэд байгууллагын регистрийн дугааргүй шатахууны 5,778.5 мянган төгрөгийн баримт байна. Анхан шатны баримтаар нотлогдохгүй, зардлаар хүлээн зөвшөөрөгдөхгүй гүйлгээ шилжүүлэг хийгдсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн зарчимтай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал алдаатай хөтлөгдөж, тайлагнагдах

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар журмуудыг мөрдөх, хүчин төгөлдөр баримттай гүйлгээ хийх,

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зардлын гүйлгээ хийхдээ Ebarimt-аар тулгаж тохируулж байхаар цаашид анхааран ажиллах болно. Хувь хүн дээр сугалааны дугаартай баримт авахгүй ажиллах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/84/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материалын тайлан, орлого зарлагын гүйлгээг түүвэрлэн шалган үзэхэд орлогын падаангүй, харилцагч байгууллагын дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримгүй 4,693.4 мянган төгрөгийн бараа материалын орлого байна.	4,693.4	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бямбасүрэн А.Нэргүйбаатар
2	Тээвэр шатахуун зардлын дансыг шалган харилцахын анхан шатны баримтуудтай тулган үзэхэд байгууллагын регистрийн дугааргүй шатахууны 5,778.5 мянган төгрөгийн баримт байна. Анхан шатны баримтаар нотлогдохгүй, зардлаар хүлээн зөвшөөрөгдөхгүй гүйлгээ шилжүүлэг хийгдсэн байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн зарчимтай нийцэхгүй байна.	5,778.5	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бямбасүрэн А.Нэргүйбаатар
3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хэвшүүлээгүй, нийт 136 мэдээлэл оруулахаас 18 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бямбасүрэн А.Нэргүйбаатар
ДҮН		10,471.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 120/АД16 0058

Улаанбаатар хот

САГ-2021/84/СТД-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 136 мэдээлэл оруулахаас 18 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал М.Бямбасүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Ж.ОЮУНБИЛЭГ



This image shows a full page of a document template. It consists of approximately 30 horizontal dotted lines spaced evenly down the page, providing a guide for handwriting or typing. The background is plain white, and there are no margins, headers, or footers visible.

[illegible]